



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/04

Эрдэнэт

**Аймгийн 2023 онд ойгоос бэлтгэх
модны дээд хэмжээ батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” А/327 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн 2018 оны ойн зохион байгуулалтын ажлын тайлан, ойн менежментийн төлөвлөгөөг харгалзан 2023 онд Жаргалант сумын хэмжээнд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг ойн цэвэрлэгээний ажлаар хэрэглээний хуурай шинэс мод 200 шоометр, түлээний шинэс мод 600 шоометр тус тус баталсугай.

2. Холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу ойгоос бэлтгэх модны төрөл тоо, хэмжээг нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага тус бүрээр тогтоохыг Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

ДАРГА  Д.МӨНХБАТ